



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 109

Мандалговь

Г Үнэлгээ тогтоож, хөрөнгө худалдах тухай Г

Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсгийн 77.2.3, 77.3, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 2.1.7, 5.8.а дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Говь-Угтаал сумын Хүүхдийн цэцэрлэгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 35,814,533.76 /Гучин таван сая найман зуун арван дөрвөн мянга таван зуун гучин гурван төгрөг далан зургаан мөнгө/-ний анхны өртөгтэй, 19,548,766.36 /Арван есөн сая таван зуун дөчин найман мянга долоон зуун жаран зургаан төгрөг гучин зургаан мөнгө/-ний хуримтлагдсан элэгдэлтэй цэцэрлэгийн хуучин барилгыг газаргүйгээр худалдах үнийн доод хязгаарыг 4,000,000.00 /дөрвөн сая төгрөг/-өөр тогтоон худалдахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Хөрөнгө худалдах нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

Гурав. Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Говь-Угтаал сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч (А. Алтанчимэг)-т даалгасугай.

Дөрөв. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.СҮХБААТАР

